

УЛСЫН ТӨСВИЙН ГААЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА  
(2022 ОН)

**Нэг. Гаалийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн ерөнхий мэдээлэл**

Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Гаалийн байгууллага нь 2022 онд тодотголоор 4.1 их наяд төгрөг Улсын төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээсэн. Гаалийн байгууллага нь 4669.0 төгрөг төвлөрүүлж 113.9 хувийн гүйцэтгэлтэйгээр, 570.4 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн үзүүлэлтэй гарлаа./ Хүснэгт№1./

*Хүснэгт№1. Орлогын гүйцэтгэл, тэрбум төгрөг*

Үзүүлэлт	2021 он	2022 он				Нийт өөрчлөлт, дүнгээр
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь	
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>3,508.2</b>	<b>4,098.5</b>	<b>4,669.0</b>	<b>570.4</b>	<b>113.9%</b>	<b>1,160.8</b>
1.1 Гаалийн албан татвар	943.1	1,081.9	1,292.2	210.3	119.4%	349.1
1.2 НӨАТ	1,902.4	2,216.8	2,723.1	506.3	122.8%	820.7
1.3 Архи, дарсны ОАТ	20.4	21.4	35.5	14.1	166.1%	15.2
1.4 Тамхины ОАТ	130.8	157.0	141.7	-15.3	90.2%	10.9
1.5 Шар айрагны ОАТ	5.8	3.8	9.1	5.3	239.8%	3.3
1.6 Суудлын автомашины ОАТ	202.6	260.0	281.8	21.8	108.4%	79.2
1.7 Автобензин, Дизель түлшний ОАТ	240.4	270.0	88.3	-181.7	32.7%	-152.2
1.8 АБДТАТ	16.6	17.2	19.4	2.2	112.5%	2.8
1.9 Экспорт	0.037	0.040	0.019	-0.021	47.8%	-0.018
<b>1. ТАТВАРЫН ДҮН</b>	<b>3,462.2</b>	<b>4,028.1</b>	<b>4,591.1</b>	<b>563.0</b>	<b>114.0%</b>	<b>1,128.9</b>
2. Хураамж	39.9	53.1	62.1	9.0	116.9%	22.1
3. Өөрийн орлого	6.1	17.3	15.8	-1.5	91.5%	9.7

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс **1160.8 тэрбум** төгрөгөөр 33.1 хувиар өссөн байна. Үүнээс:

- Гаалийн албан татвар **349.1** тэрбум төгрөг, Архи, дарсны онцгой албан татвар **15.2** тэрбум төгрөг,
- Тамхины онцгой албан татвар **10.9** тэрбум төгрөг,
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар **820.7** тэрбум,
- Суудлын автомашины онцгой албан татвар **79.2** тэрбум төгрөг,
- Өөрийн орлого **9.7** тэрбум төгрөг,
- Автобензин, дизелийн түлшний албан татвар **2.8** тэрбум төгрөг,
- Хураамжийн орлого **22.1** тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар **152.2** тэрбум төгрөг, экспортын гаалийн албан татвар орлого **18 сая** төгрөгөөр тус тус буурсан байна

